



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 10 сарын 20 өдөр

Дугаар А/363

Мөрөн сум

Зөвлөл байгуулж, журам батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 66.3, Төсвийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.5, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалын 4.1 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Засаг даргын зөвлөлийг доорх бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

1. Аймгийн Засаг дарга
2. Аймгийн Засаг даргын орлогч
3. Аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга
4. Аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга
5. Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга
6. Аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга
7. Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга
8. Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга
9. Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтсийн дарга
10. Аймгийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабын дарга
11. Орон нутгийн өмчийн газрын дарга
12. Санхүүгийн хяналт, аудитын албаны дарга
13. Аймгийн Үйлдвэрчний эвлэлийн холбооны дарга
14. Монголын Үндэсний Худалдаа, аж үйлдвэрийн танхимын Хөвсгөл аймаг дахь салбарын дарга

2. Аймгийн Засаг даргын зөвлөлийн ажиллах журмыг хавсралтаар баталсугай.

3. Энэ захирамж гарсантай холбогдуулж аймгийн Засаг даргын 2021 оны А/41 дүгээр захирамжийг хүчингүйд тооцсугай.

4. Захирамжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (П.Ариунбат)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Ш.ИДЭРБАЯСГАЛАН